

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/12-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Т.Одсүрэн Утас: 99499667 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

1. Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	10
3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
4.Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4 Материаллаг байдал.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14



“СЭЛЭНГЭ БАЯЛАГ ИРЭЭДҮЙ”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Д.ЭНХСҮХ
ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/12-НА-ТА-ОНА
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторовын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	МНӨА00003 3000.00 -
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	170,452.00	23,592.00
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	170,452.00	23,592.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	Нийт хөрөнгийн дүн	170,452.00	23,592.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	-
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	-	-
2.3.1	-төрийн		
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,263,757.60)	170,452.00
2.3.10	Тайлант үеийн ашиг/ алдагдал	3,434,209.60	(146,860.00)
2.3.11	Эздийн өмчийн дүн	170,452.00	23,592.00
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	170,452.00	23,592.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)		4317143988
2	Борлуулалтын өртөг		110040065 9055436
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	3,500,000.00	
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал		
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	65,790.4	146,860.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,434,209.60	(146,860.00)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,434,209.60	(146,860.00)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,434,209.60	(146,860.00)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	3,434,209.60	(146,860.00)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл			-	(3,288,057.60)	(3,288,057.60)
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			24,300.00	24,300.00
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	(3,263,757.60)	(3,263,757.60)
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,434,209.60	170,452.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	170,452.00	170,452.00
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-		-
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-		
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(146,860.00)	(146,860.00)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	23,592.00	23,592.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	3,500,000.00	-
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,500,000.00	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого		-
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,341,306.00	146,860.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,286,514.00	-
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	804,300.60	-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		-
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	221,648.00	-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	28,843.40	146,860.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	158,694.00	146,860.00
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	158,694.00	(146,860.00)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	11,758.00	170,452.00
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	170,452.00	23,592.00

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	-	-	-	-	-
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	-	-	-	-	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	3,500.0	-	-	-	-
3	Нийт зардал	м/төг					
	Үүнээс:	м/төг					
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-				
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	65.8		146.9	-	-
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг	-	-	-	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	3,434.2	-	(146.9)	-	-

1. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус газрын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Гадаад, дотоод худалдаа,
- Байгаль орчны тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах,
- Туслах үйл ажиллагаа.

Тус газрын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХТ-ийн 2017 оны 5 дугаар 02-ны өдрийн 58 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх” 18 дугаар зүйлийн 18.1.3ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	170.4	23.5	(146.9)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	170.4	23.5	(146.9)
Өр төлбөр		-	
Хуримтлагдсан ашиг/+/, алдагдал/-/	170.4	23.5	(146.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	170.4	23.5	(146.9)

Банкин дахь харилцах дансанд байгаа мөнгөний үлдэгдэл болон нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгийн өмчийн дүн 23.5 мянган төгрөг болж өмнөх оноос 146.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй боловч арилжааны банкны данс хөтөлсөн үйлчилгээний хураамжийг төлснөөс шалтгаалсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Сэлэнгэ баялаг ирээдүй" ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаа эрхлэн явуулах чиглэлээр 2017 онд Сэлэнгэ байгалийн нөөц, Сэлэнгэ хаш баялаг, Сэлэнгэ ресурс орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-иудыг байгуулсан байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой байгуулагдсан дээрх компаниудын (20-34) хувийн хувьцаа эзэмших зорилго бүхий "Сэлэнгэ баялаг ирээдүй" ОНӨААТҮГ-г аймгийн ИТХТ-ийн 2017 оны 5 дугаар 02-ны өдрийн 58 дугаар тогтоолоор төрийг төлөөлүүлэн үүсгэн байгуулсан байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолуудаар дээрх 3 компанид гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга Ш.Оргилд үүрэг болгосны дагуу "Сэргээгдэх байгалийн нөөц" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан орон нутгийн өмчийн оролцоотой "Сэлэнгэ байгалийн нөөц" ХХК-ийг 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулж, Сэлэнгэ хаш эрдэнэ, Хөх бүрдийн эх компаниудтай гэрээ байгуулаагүй байна.

Ингэснээр "Сэлэнгэ баялаг ирээдүй" ОНӨААТҮГ нь хамтран ажиллах гэрээ байгуулсан "Сэлэнгэ байгалийн нөөц" ХХК-ийн 34 хувийг эзэмшихээр болсон боловч аймгийн ИТХТ-ийн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолоор

“Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ийн 34 хувийн хувьцаа эзэмшигч “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын хувьцаанаас 8 хувийг Баянгол суманд эзэмшүүлэх шийдвэр гаргасны дагуу “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ нь “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ийн 26 хувийн хувьцааг эзэмшихээр зохицуулагджээ.

“Сэлэнгэ байгалийн нөөц” орон нутгийн өмчийн оролцоотой ХХК нь 2017 онд Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутагт ХҮ-020879 дугаартай, Баянгол сумын нутагт ХҮ-020950 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авч, Ашигт малтмал, газрын тосны газарт жил бүр тайлангаа хянуулж, дахин 3 жилээр хугацааг сунгасан байна. Баянгол сумын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газарт 2019 оны 4 дүгээр сард МҮ-021321 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай авсан байна.

Баянгол сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сэлэнгэ байгалийн нөөц” орон нутгийн өмчийн оролцоотой тус компанийн ашиглалтын зөвшөөрөл бүхий газар нь нь УБ-Дархан чиглэлд тавигдаж буй олон улсын зам дагуу байрладаг учир үйл ажиллагаа явуулж эхлээгүйгээс шалтгаалан дагуу “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-т хувьцааны ногдол ашиг хуваарилаагүй, 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

4.Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Сэлэнгэ баялаг ирээдүй” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид Сэлэнгэ баялаг ирээдүй ОНӨААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Тайлант онд тус газар нь үйл ажиллагаа явуулаагүй учир дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,471.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 34.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд тус газар нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй учраас шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээлэл байхгүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ нь 2017 онд байгуулагдсан үеэс хойш дүрмэнд тусгагдсан чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй нь “Сэлэнгэ байгалийн нөөц”, орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-ийн үйл ажиллагаатай шууд хамааралтай байна.

Иймд “Сэлэнгэ байгалийн нөөц” орон нутгийн өмчийн оролцоотой компани нь байгуулагдсанаас хойш үйл ажиллагаа явуулсан эсэхийг дараагийн аудитаар тулган баталгаажуулах шаардлагатай юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.